*Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!*

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

*Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.*

17 дэх жилдээ
№ 46 (1381)

1964 оны
6 дугаар сарын 11

ПҮРЭВ

## Хадлангийн бэлтгэлийг сайн хангая

Өвс хадланг ургамлын шимт угацааны дотор их хэмжээтэй бэлтгэж авах өвөл хаврын хатуу улирлыг зутралгүй давах, малынхаа ашиг шимийг гүйцэд ашиглах, төл хүлээн авч бойжуулах чухал нөхцөл болдог билээ.

1964 онд сангийн аж ахуй, нэгдэл, түүний тасаг, бригад бүр малдаа байгалийн арвин их өвс хадланг нарийн зохион байгуулалттай богино хугацаанд бэлтгэн авах ээлжит зорилт тулгарч байна.

Аймгийн хэмжээгээр энэ онд 103,8 мянган тонн өвс хадлан авах нийтийн кампанит ажилд 7 дугаар сарын 20-оос жигдрэн орно. Өвс хадлан бэлтгэх нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн амин чухал ажил байдаг боловч урьд жилүүдийн туршлагаас үзэхэд зарим сангийн аж ахуй, станц, нэгдлүүд энэ ажилд сайн бэлтгэхгүй, ялангуяа зохион байгуулалт урьдчилан хийдэггүй, морьдыг сургах, хадлангийн машин багажийг засварлаж бэлэн болгох, хадах талбайг сонгон авч цэвэрлэх, хамгаалах ажил хийдэггүй ноцтой дутагдал давтагдан гарсаар байв.

Өнгөрөгч онд Баяндэлгэр, Баянжаргалан, Дэлгэрхаан, Бүрэн, Лүн сум—нэгдлийн удирдлагууд хадлангийн бэлтгэлийг муу хийсэн төдийгүй ургац гүйцээгүй, морьд сургаагүй, жигдрэх болоогүй гэх зэргээр олон шалтаг вааж хариуцлагагүй хандсны уршгаар их ургац авах үүргээ тасалдуулсан ба хадлангийн ажлыг унжруулан эцэс сүүлд нь цагаан өвс хадаж байв. Улс ба нэгдэлд техникийн хүчээр өвс хадаж, пресслэж шилжүүлэх үүрэгтэй Баяндэлгэр, Сэргэлэнгийн МААМС—ын удирдлагууд хадлангийн ажилд хүн хүч, машин техникээ гүйцэд ашиглаж чадахгүй байсаар намрын тариа хураалтын ажилтай давхцуулан өөрийн үүргээ унагааж байв.

Дээрх дутагдлыг энэ онд давтаж болохгүй.

Сангийн аж ахуй, МААМС, нэгдэл бүр энэ оны хадлан авалтыг 40—45 хоногийн догор заагал дуусгасан байх ёстой. Станцуудад трактор хадуур 27, пресс 16, нэгдлүүдэд морин хадуур 820 байгаа нь төлөвлөгөөт хадланг бараг механикжуулсан техникийн хүчээр бэлтгэх ашигтай сайн боломж байна. Иймд хадлангийн амжилт гагцхүү бэлтгэл зохион байгуулалт хир зэрэг хангагдсанаар шийдвэрлэгдэнэ гэдгийг орон нутгийн нам, улс, олон нийт аж ахуйн байгууллагын удирдлагууд анхаарч одоогоос бэлтгэл ажлыг шуурхай хийх хэрэгтэй. САА, нэгдэл, станцууд хадаж болох ургац бүхий талбайг сонгон авч түүнд шаардагдах техникийн тооцоог гаргаж, дутагдах багаж техникийг түргэн татаж авах, хадлангийн талбай цэвэрлэх, нөөцлөн хамгаалах ажлыг яаравчлан хийх нь чухал.

САА, станц, нэгдэл бүр хадуур, тармуур бусад машиныг сэлбэн засварлах, засварын бригад хэсгийг зохион байгуулж ажилд нь оруулбал зохино.

Алтанбулаг сум—нэгдлийнхэн 6 дугаар сарын 20 доор морьдоо цөмийг сургаж морин машин тармуурыг засварлаж бэлэн болгоод сумын төвд нэгдсэн үзлэг, морин машины цуваа зохиохоор ажиллаж байгаа нь нийтэд жишээ болж байна.

Сумдын төвд морин машинд морь сургах, залуучуудын бригадыг 6 дугаар сарын эхний хагаст зохион байгуулж үр бүтээлтэй ажиллуулах хэрэгтэй байна.

САА, станц, нэгдэл бүр хадланд ажиллах хүмүүсийн нэрсийн жагсаалт, бригадууд тэдгээрийн дарга, тоо бүртгэгч, ашиглах техник, авах ургацыг одоо тооцоолон, хадланчдад олгох хөлсний хэмжээ ажлын нормыг боловсруулж нийтэд тайлбарлан таниулах ажил зохиох хэрэгтэй.

Нэгдлүүд, хадланд бэлтгэх ажлыг бригад хэсгүүдэд хуваарлан хариуцуулж, даалгавар өгөх, шалгаж үзэх ёстой. Хадлангийн талбайн ургацыг зоотехникч нар чанараар нь ангилан үзэж хадах өвсийг төл тэжээх, бод бог мал тэжээх гэх зэргээр ялгах ажлыг 7 дугаар сарын эхний 10 хоногт явуулж зохих акт тодорхойлолтыг гаргасан байх.

МААМС—ууд, улсын фонд хадах трактор, хадуур машиныг нэг бүрчлэн бэлэн болгож хүн хүчний зохион байгуулалтыг хийхийн хамт үйлчлэх нэгдлүүдийн дугуйт трактор, угсрах механизм, хадуур тармуурыг засаж бэлтгэхэд нь запас хэрэгслэл, мэргэжлийн хүнээр туслах ёстой. Сумын захиргаадаас хадлангийн бэлтгэлийг тасаг бригад, суурь, хэсэг бүрт шалгаж хүлээн авах ажлыг 7 дугаар сарын эхээр хийх нь зүйтэй байна.

Хадлангийн бригадуудын орон сууц, гэр майхныг сэлбэх, хоол хүнсийг татаж авах, хуваарлах, соёл гэгээрэл, хангамжийг тооцоолон бүрэн бэлтгэх нь чухал.

Туршлгатай хадланчдаар морин машин, тармуур, морьдыг эдэлж эзэмших арга техникийг нийт хүмүүст заалгах, үзүүлэх, хадланчин бүрийн ажлын арга техникийг сайжруулах, нам, эвлэл, эмэгтэйчүүдийн байгууллагаас арвин их хадлан авахын ач холбогдол, хадах, тармах, нуруулдах, арга техникийг өргөнөөр сурталчлах хэрэгтэй.

Хадланчдын ухамсар сахилга бат, зохион байгуулалтыг дээшлүүлэх талаар ухуулан таниулах ажлыг нийт хөдөлмөрчдийн дунд зохиохын хамт үйлдвэр, аж ахуй, албан газрууд өөрийн шеф нэгдэл, сангийн аж ахуйд хүн хүч, багаж хэрэгслэл бүхий бригад гаргахад бэлтгэх хэрэгтэй байна.

1964 оны хадлангийн бэлтгэл ажлыг хангахад хөдөлмөрч хүн бүрийг оролцуулах ажил богино хугацаанд шуурхай хийх нь одоогийн гол зорилт болж байна.



ЗУРАГ ДЭЭР: Баян сумын «Монгол—Польшийн найрамдал» нэгдлийн 3 дугаар бригадын саальчин сумын депутат Ч.Чимэдрэгзэн, суурийн ахлагч С.Цэдэнтэй үнээний сүүний гарцыг нэмэгдүүлэх талаар зөвлөж байгаа нь.

*(Г.Шагдарсүрэнгийн авсан гэрэл зураг)*

## Уринш хагалалт

Жаргалантын сангийн аж ахуй 1964 онд 15189 га уринш хагалана. Үүнийг хугацаанд нь чанар сайтай биелүүлэх зорилгоор бүх тасаг, бригадад уринш хагалалтын ажил «МТ—3», «ДТ—54» трактор 90 гаруйтай зохион байгуулагдан 6 дугаар сарын 4—нд эхлэв.

Уринш хагалалтын хамтаар хагалсан бүх талбайд борной культоботор, лүшильник тус бүр 1-3 удаа, бүгд 6 удаа хөрс боловсруулалт хийх юм. Сангийн аж ахуйн захиргаа энэ зорилтыг биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч тасаг, бригадын дарга, механикуудад семинар өгч, механикжуулагчдын дунд социалист уралдаан зарлан тусгай болзол гарган ажиллаж байна.

*Т.Банзрагч*

## Сүүний нэгэн тасагт

Баянбараат сумын «Баян амьдрал» нэгдлийн 1 дүгээр бригадын Сандаг эрхлэгчтэй сүү хүлээн авах тасаг бүгд 236 үнээ, 15 саальчинтай ажилдаа орж одоогийн байдлаар 3476 литр сүү хүлээн авч байна.

Тасгийн эрхлэгч Сандаг, тасаг зохион байгуулалтыг сайн хийж биеийн тамирын талбай, халуун усны газар байгуулаад ажиллаж байна. Тус тасагт хүмүүжлийн ажил тогтмолжиж цагийн хуваараар явагдаж байна. Энэ тасагт 12—14 жил тасралтгүй ажиллаж байгаа ажилчин Дэлэг, Дашдэндэв нар маш идэвхтэй ажиллаж байна.

*Ц.Жадамбаа*

## Оторт гарсан хонь

Зун цагт малыг тарга хүч авахуулахын нэг чухал нөхцөл бол отроор таргалуулах ажил юм. Баянжаргалан сум энэ жил 30 гаруй мянган мал суурьлан оторлож байна. Хонь отроор таргалуулах ажилд өвгөн хоньчин Дорж, 1 дүгээр бригадын суурийн ахлагч Шагаа нарын олон малчин мэрийлттэй ажиллаж хонины дундаж тарга 35—45 кг-д хүрч байна.

*Б.Өлзийхутаг*

## Тэмцэе

**Хуулийн байгууллагууд зөвхөн гаргасан хэргийг хагас дутуу барагдуулснаар ажлаа хязгаарлаад, хамгийн гол зүйл болсон тогтворгүй хүмүүст санамж дохио болгож сахилгажуулах ажил муу, шүүх хурлын хүмүүжүүлэх роль хангалтгүй байна**

Социалист өмч хөрөнгийг хайрлан хамгаалдаггүй, түүнд нарийн тооцоо нэвтрүүлэхгүй, жинхэнэ эзний ёсоор харж хямгадахгүй байгаагаас улс, хоршооллын өмч хөрөнгийг зальт этгээдэд алдаж үрэгдүүлэх явдал худалдааны байгууллагат багагүй байна.

Аймгийн худалдаа бэлтгэлийн байгууллагын харуул манааны хүмүүсийн 60 гаруй хувь нь хөдөлмөрийн чадваргүй, өндөр настай хүмүүс байгаа бөгөөд харуул манааны ажил сул байгаа нь сонор сэргэмж алдаж, ажлын хариуцлага сулруулж байгаа ноцтой дутагдал болж байна. Гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн зонхилох хэсэг нь идэр залуучуудын дунд их байгаа нь тэдний зан харилцаанд соёлч боловсон байдлыг муу нэвтрүүлж, тэдэнтэй цаг бие хайргүй ажиллах хүмүүжүүлэх ажил төв, хөдөөд жигд зохиогдохгүй байгаад оршино.

Иймд буруу зан төрхтэй залуусыг хүмүүжүүлэх талаар аймгийн нам, олон нийт, засаг захиргаа, хуулийн болон ХЗЭ-ийн байгууллага хүмүүжил, ухуулгын олон хэлбэрийг ашиглан даалайцтай ажил зохиох хэрэгтэй байна.

Ялангуяа амьдралын туршлага суугаагүй, тэсвэр хатуужил муутай залуусыг эцэг эхийн ёсоор энэрэн хүмүүжүүлэх явдал нэн чухал байгааг зарим албан байгууллага, нэгдэл, сангийн аж ахуйн удирдлага гоц анхаарах ёстой.

Гэмт хэргийг эрс багасгах ажлын уг сурвалж бол хуулийн болон нам, олон нийтийн байгууллагын жигд хамтын байнгын ажил мөн.

◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆◆

байдаг байна.

Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх захиргааны галын аюулаас урьдчилан сэргийлэх, архивын бичиг хэргийг цэгцлэх арга хэмжээний тухай тогтоолуудыг Эрдэнэ, Өнжүүл, Бүрэн, Баянбараат сумд, Эрүүлийг хамгаалах газар, 13 дугаар авто бааз зэрэг албан газрууд хангалтгүй биелүүлж байгаагийн дээр Дэлгэрхаан, Заамар сумдын гүйцэтгэх захиргаа, Эрүүлийг хамгаалах газрын нэгдсэн больницод гарсан тогтоол тушаалд эрхийн норм хэмжээ зөрчигдөх явдал үзэгдэж байна.

Энэ мэт дутагдал үргэлжилсээр байна.

Гүйцэтгэлийн шалгалтыг явуулахдаа хийсэн ба хийж байгаа ажлыг шалгаад зогсох биш дутагдлы нь илрүүлэх шуурхай арга хэмжээ авах, даалгавар өгөх, зааварлах, хөдөлмөрчдийн хурал зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэн уг дутагдлыг газар авахуулахгүй засах талаар шуурхай ажиллах хэрэгтэй.

Засаг, төрийн байгууллагуудаас зөв хийгдсэн гүйцэтгэлийн шалгалт бол гаргасан тогтоол шийдвэрүүдийг заагдсан хугацаанд нь биелүүлэхэд олон нийтийн итгэх итгэлийг улам өндөржүүлдэг юм.

*Ц.Очир*




# *ЗАЛУУ НАС—БҮТЭЭЛЧ ҮЕ*

**(ТЭМДЭГЛЭЛ)**

### Эд нар хаа явах нь вэ?

Тэнгэрийн хаяанаас дээшилж буй өглөөний нар, Зуун мод хотын орчныг нэлэнхүйд нь гийгүүлэв.

«Төв аймгийн МХЗЭ—ийн хороо» гэсэн алтан шаргал хаяг бүхий цагаан байшингийн үүдэнд туг лозунгоор чимэглэгдсэн авто машинууд эгнэн зогсож, түүний зүг хөрөө сүх, хүрз лоом, төмөр утас, хадаас барьцгаасан залуус тал бүрээс хуран цуглаарч байв.

—Эд нар хаа явах нь вэ?

—Хөшигийн хөндий.

—Юу хийх юм бол?

—Олон төрлийн туршлагын функт барих юм—гэхчилэнгээр нэгэн гэрийн эмгэн, өвгөн хоёр ярилцахын зэрэгцээ залуу насаа гэж юуг ч бүтээх лут чадалтай үедээ гэж бахархан ярина.

Төдхөн аянд гарахынхаа өмнө цуглаан хийж, аймгийн ХЗЭ—ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Д. Товуу «Хөдөлмөр—соёлын 100 хоногийн дайчин цуваа» аймгийн хэмжээгээр амжилттай явагдаж байгааг дэлгэрэнгүй баримтаар яриад, олон төрлийн туршлагын функт барих ажилд сайхан амжилт олохыг залуучуудад уриалав.

—Машин хөдөллөө.

Намуухан салхинаа туг дэрвэж, залуусын дуу хөг нийлэн цурайтсаар Хөшигийн хөндий чиглэв.

Тарьсан тариа соёолон, хагалсан атар хүрэнтэн байгаа Хөшигийн хөндийд асар майхан эгнэн ярайж, ажлын эхлэл амилан хөдөллөө.

—Гартаа нилээд том хэмжээний цаас дэлгэн барьсан хоёр орос хүн хэсэг монгол нөхдийн хамт ямар нэгэн зүйл зааж зааварлаж байгаа бололтой.

Тэр бол олон төрлийн туршлагын функтийн зураг төслийг зохион бүтээсэн зөвлөлтийн мэргэжилтэн Чижов, В. Давыдов нар ажээ.

Залуус 3 бригад болон тус тусынхаа ажилд орлоо.

Хөрөө сүхний дуу хоршин эгшиглэж, хөдөлмөрийн их нүргээн Хөшигийн хөндийг уяруулав.

Цаг мөч өнгөрөх бүрийд ажил улам бүр түргэсэн ухуулах хуудас, мэдээлэх сонинд амжилтын мэдээ тодрон, уралдааны дүн гарч шилжин явах дарцаг бригадын ахлагчид гардуулж байв.

—Нацаг даргатай бригад хоёр ч удаа түрүүлчихлээ.

—Төмөрхүүгийн бригад нэг удаа авчихлаа.

—Цэрэндондовын бригад шагнагдлаа.

Одоо хаанах нь авах бол гэхчилэнгээр залуусын хөгжилтэй яриа ажлын дундуур амнаас ам дамжина.

Залуус дандаа л ажиллаад байсангүй, чөлөө цагаараа тоглоом наадам болцгоож, шөнийн цагаар кино үзэцгээх буюу цүү хаяна.

Тэмцээн явуулж тэргүүн байр булаалцалдана.

Энэ бүхэн залуучуудын хөдөлмөрлөх идэвхийг улам оргилуулж их амжилтанд уриалж байлаа.

### Ажлын дүн гарч, амжилтын мэдээ сонсоход

Оройн 19 цаг боллоо.

Аймгийн соёлын ордны зүг хүмүүс хэсэг хэсгээр, ганц нэгээрээ их л яаран алхалж яваag харахад тэнд ямар нэгэн чухал ажилтай нь илтээ.

Төдий л удалгүй үзэгчдийн танхимийн суудал хүмүүсээр пиг дүүрэв.

—Аймгийн ХЗЭ—ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга илтгэгчийн индрээс Зуун мод хотын залуучуудын хүч хөдөлмөрөөр босгогдсон олон төрлийн туршлагын функтийн ач холбогдол, тэнд ажилласан бүтээлч хөдөлмөрийг бахдан ярив.

—Залуучууд гуравхан өдрийн дотор уртаараа 120 метр, өргөнөөрөө 8 метр 18 тасалгаа бүхий 240 үнээний багтаамжтай хашаа зохиомол хээлтүүлгийн функт, өдөрт 3500—гаас доошгүй богмал угаах ваань барьж дуусгажээ.

Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн нутаг Хөшигийн хөндийд барьсан үлгэр жишээ энэ функт барихад залуучууд цөм сайн ажиллажээ.

Сайны дотор сайчуул бас байдаг. Аймгийн Гүйцэтгэх захиргааны Даваадорж, Борхүү, Хөдөө аж ахуйг удирдах газрын Капар, хүнсний комбинатын Зэсэм, Худалдаа бэлтгэлийг удирдах газрын Бархүү, Дуламсүрэн гэхчилэнгээр сайн ажилласан сайчууд олныг нэрлэж болно.

Ингэж аймгийн төвийн залуучууд хөдөлмөр—соёлын дайчин цуваагаар функт барих цуваанд гарч бахдам амжилт гарган богино хугацаанд барьж дуусгасныг харахад ёстой л залуу нас—бүтээлч үе болох нь хэний ч нүдний өмнө тодхон харагдаж байна.

Б. *Дорж*

ʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘʘ

## Ном уншигчдын зөвлөлгөөн болов

Эрдэнэ сумын МХЗЭ-ийн үүр, эвлэлийн гишүүд залуучуудын дунд ном хэвлэл, ашиглагчдын үзлэг хийж дараа нь хэвлэл, ном ашиглагчдын зөвлөлгөөн хийв.

Ном хэвлэл ашиглагчдын үзлэг, зөвлөлгөөний дүнгээс үзэхэд эвлэлийн гишүүн Нэргүй, Сэр-од нарын олон залуу ном хэвлэлтэй тогтмол нөхөрлөж, уншсан номын тэмдэглэл хөтөлдөг, захиалсан хэвлэлээ дугаараар нь хадгалж цаг үргэлж ашигладаг байна. Тус зөвлөлгөөн хэвлэл ном ашиглах талаар нилээд дутагдал байгааг илрүүлэв.

Зарим хүмүүс уншсан номын тэмдэглэлгүй, чөлөө цагийг сурч соёлжихдоо бүрэн ашигладаггүй, уншсан зүйлээ мартах, ашиг тусы нь амьдрал хүмүүжилдээ нэвтрүүлж чадаагүйн дээр зарим залуучууд бүтээсэн гойд ажилгүй хирнээ уншсан ном хэвлэл ч үгүй аар саархан юманд алмайрч цагийг үр ашиггүй өнгөрүүлдэг явдал гарч байна.

Захиалсан хэвлэлээ дугаарлан хадгалахгүй гал ноцоох, юм боох, юм арчих зэргээр үрж алга болгосноос болж шаардлагатай үед хэрэгцээтэй сонин нь олдохгүйд хүрдэг байна.

Сонин тараагч нөхөд нь хэвлэлийг удаан хугацаагаар дарагдуулах, замын хүнээр дамжуулах зэргээс болж зарим хүмүүсийн хэвлэл цаг хугацаандаа ирж эзэндээ очдоггүй гэм байгаа зэргийг илрүүлэн түүнийг засах талаар хэрхэн яаж ажиллах тухай сумын нийт хөдөлмөрчид залуучуудыг уриалсан уриалга гаргав.

Д.*Раднаабазар*.

## Эрчимтэй ажиллаж байна

Архустын сургууль комбинатынхан хөдөлмөр—соёлын 100 хоногийн дайчин цуваагаар 400 гаруй мод тарьж, 1964-1965 оны өвлийн бэлтгэлд 1800-гаад куб метр мод бэлтгэн бүгдийг татан авчээ.

Хүүхдийн тоглоомын талбай байгуулж хүүхдийн баярын өдөр ашиглалтанд оруулжээ, Тэд биеийн тамирын талбайг тохижуулан өөрсдийн хүчээр биеийн тамирын танхим барих, засварын газар байгуулахаар газар шорооны ажилд ороод байна.

С.*Товуудорж*